

НИСЛЭГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН СУДАЛГАА 2019

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА



Агаарын тээвэр хөгжихийн хэрээр агаарын навигацийн үйлчилгээний менежментийг урт хугацаанд аюулгүй, үр ашигтай, үйл ажиллагааг нь жигд, хүртээмжтэй болгох шаардлага тулгарч байгаа бөгөөд нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн оновчтой тогтолцоог бий болгож хэрэгжүүлснээр нислэгийн аюулгүй ажиллагааг дээшлүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, хүний нөөцийг зөв хуваарилах, агаарын замыг уян хатан, чөлөөт байдлаар ашиглах, агаарын зайн багтаамжийг нэмэгдүүлэх, нислэгийн хөдөлгөөнийг оновчтой хуваарилах, агаарын зайн ашиглалтыг сайжруулах, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийг үр дүнтэй хийх, урсгал төлөвлөлтийн арга хэрэгслүүдийг ашиглах бодит боломж бүрдэх юм.

Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн бүрэлдэхүүн хэсэг болох үйл ажиллагааны дараах дүн шинжилгээ хийх нь шинээр нэвтрүүлэх, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад тус нэмэр болно гэдэгт итгэж байна.

ӨМНӨХ ҮГ

Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Иргэний нисэхийн үндэсний төвийн Агаарын навигацийн үйлчилгээний газрын Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба нь Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль, Иргэний нисэхийн багц дүрмүүд болон Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/427 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам", тус албаны "Үйл ажиллагааны заавар"-ыг мөрдлөг болгон дотоод, гадаадын агаарын тээвэрлэгчдээс Монгол Улсын агаарын зайд үйлдэх нислэгийн хүсэлтийг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн, нислэгийн зөвшөөрөл олгон урт хугацааны, урьдчилсан, шуурхай төлөвлөлтийг хийж, батлагдсан нислэгийн төлөвлөлтөнд орох өөрчлөлтийн мэдээ, мэдээллүүдийг боловсруулан, агаарын навигацийн үйлчилгээний газрын харьяа алба болон бусад алба, салбар, төв, орон нутгийн нисэх буудлуудыг нислэгийн төлөвлөлтийн мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна.

Мөн Монгол улсын агаарын зайгаар нисэн гарсан болон бууж, хөөрсөн олон улс, орон нутгийн нийт нислэгийн гүйцэтгэлийн мэдээллүүдийг "Нислэг төлөвлөх, гүйцэтгэл бүртгэх" сүлжээнд бүртгэн, хянаж, нислэгийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, судалгааг төрөл бүрээр гарган иргэний нисэхийн байгууллагууд болон холбогдох мэргэжилтнүүдэд өдөр, сар, жилээр тогтмол түгээн, бодлогын хэмжээнд хийгдэж буй үйл ажиллагааны хэрэгжилт, явцыг бодитоор дүгнэхэд зохих хувь нэмрээ оруулжээ.

Ийнхүү тогтмол гаргадаг тоон болон судалгааны мэдээллүүдээ эмхтгэн нэгтгэж, 2019 онд Монгол улсын агаарын зайгаар нисэн өнгөрсөн болон бууж, хөөрсөн олон улс, орон нутгийн нийт нислэгийн төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээ, судалгааг сар, улирал, жил, нислэгийн төрөл болон захиалгын төрөл, аяллын төрөл, агаарын тээвэрлэгч компани, агаарын хөлөг, агаарын зам, нисэх буудал, сектороор болон өмнөх жилүүдийн гүйцэтгэлтэй харьцуулан өсөлт, бууралтын тоо, хувиар гарган Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн үйл ажиллагааны дараах дүн шинжилгээг хийж та бүхэнд толилуулж байна.

"НИСЛЭГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН СУДАЛГАА 2019" эмхтгэлд орсон мэдээллүүдээс дэлгэрэнгүйгээр авах болон мэдээллийн талаарх санал хүсэлт, тодруулгыг тус албаны tpu@mcaa.gov.mn болон sarantogtokh.ts@mcaa.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хянасан:
НУТАлбаны дарга
Ч.Одгэрэл

Боловсруулсан:
НУТА-ны судалгааны мэргэжилтэн
Ц.Сарантогтох

Эх бэлтгэсэн:
НУТА-ны Бүртгэл гүйцэтгэлийн оператор
Д.Балт

Утас: 71281642 И-Мэйл: fpd_office@mcaa.gov.mn
Факс:70049680 sarantogtokh.ts@mcaa.gov.mn

ГАРЧИГ

НЭГ. 2019 ОНЫ НИЙТ НИСЛЭГ
НИСЛЭГИЙН ХАРЬЦАА....4
НИСЛЭГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ....5
НИЙТ НИСЛЭГИЙН ХАРЬЦУУЛАЛТ....7
НИСЛЭГИЙН ЗОРИЛГО....9
АГААРЫН ХААЛГА....9
ЧИГЛЭЛ....10

ХОЁР. АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧ
АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИД....11
НИСЛЭГИЙН ТӨРӨЛ....13

ГУРАВ. АГААРЫН ЗАМ....18
ДӨРӨВ. АГААРЫН ХӨЛӨГ....20
ТАВ. ӨНГӨРӨЛТИЙН НИСЛЭГ (НИСЭХ БУУДАЛ)
ТИВ....22
УЛС....23
НИСЭХ БУУДАЛ....24

ЗУРГАА. АЧААЛЛЫН СУДАЛГАА
ӨНГӨРӨЛТИЙН НИСЛЭГИЙН АЧААЛАЛ....27

ДОЛОО. СЕКТОР
ӨНГӨРӨЛТИЙН НИСЛЭГ....30

НАЙМ. НИСЛЭГИЙН ЗАМЫН УРТ 32
ЕС. ОЛОН УЛСЫН НИСЛЭГИЙН ЦАГ....34
АРАВ. ЗАХИАЛГЫН ТӨРӨЛ
ӨНГӨРӨЛТИЙН НИСЛЭГ....35

АРВАН НЭГ. АЯЛЛЫН ЗОРИЛГО
ӨНГӨРӨЛТИЙН НИСЛЭГ....37

АРВАН ХОЁР. 2010-2019 ОНЫ НИЙТ НИСЛЭГ
ХАРЬЦУУЛАЛТ....39

ХАВСРАЛТ....40

НЭГ. 2019 ОНЫ НИЙТ НИСЛЭГ

Иргэний нисэхийн ерөнхий газрын Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба нь 2019 онд нийт 55 улсын 236 агаарын тээвэрлэгч компаниудын олон улс, орон нутгийн 317618 нислэгт холбогдох хууль, журам, зааврын дагуу зөвшөөрөл олгон төлөвлөснөөс 53 улсын 224 агаарын тээвэрлэгчийн 151772 нислэгийн гүйцэтгэл хийгдэж, төлөвлөсөн нислэгийн гүйцэтгэл 47.8%-ийн биелэлттэй байсан байна.



Нийт нислэгийн 88.1% нь олон улсын өнгөрөлтийн, 6.7% нь олон улсын хөөрөлт, буултын нислэг, 5.2% нь орон нутгийн нислэг байж, нийт нислэгийн 94.8%-г олон улсын нислэг эзэлж байна. Үүнээс өнгөрөлтийн нислэг 92.9%, олон улсын хөөрөлт, буултын нислэг 7.1% байна.



Утас: 71281642 И-Мэйл: fpd_office@mcaa.gov.mn
Факс:70049680 sarantogtokh.ts@mcaa.gov.mn

НИЙТ НИСЛЭГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

Нислэгийн төрөл



Захиалгын төрлөөр

2019 онд нийт нислэгийн 90.2% нь хуваарьт нислэг, 9.8% нь хуваарьт бус нислэг эзэлж байна. Олон улсын өнгөрөлтийн нислэгийн ихэнх буюу 93.6%, олон улсын хөөрөлт, буултын нислэгийн 82.5%-г хуваарьт нислэг эзэлж байгаа бол орон нутгийн нислэгт 43.3% нь хуваарьт нислэг, 56.7% нь хуваарьт бус нислэг байжээ.

2019 онд олон улсын өнгөрөлтийн хуваарьт нислэгийн төлөвлөгөөний биелэлт 43.8%, олон улсын хөөрөлт, буултын нислэгт 92.1%, орон нутгийн хуваарьт нислэг 71.0% тус тус гүйцэтгэгдсэн байна.

Хуваарьт бус нислэгийн хувьд өнгөрөлтийн нислэг 79.2%, олон улсын хөөрөлт, буултын нислэг 87.6%, орон нутгийн нислэг 92.2% тус тус гүйцэтгэгдсэн байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 1.1 харна уу.

Олон улсын өнгөрөлт

Захиалгын төрөл	Төлөвлөлт	Гүйцэтгэл	**Биелэлт%**	**Тухайн нислэгт эзлэх%**
Хуваарьт	296746	125089	**43.8%**	**93.6%**
Хуваарьт бус	10831	8574	**79.2%**	**6.4%**
Нийт дүн	285915	133663	**45.0%**	**100.0%**

Олон улсын хөөрөлт, буулт

Захиалгын төрөл	Төлөвлөлт	Гүйцэтгэл	**Биелэлт%**	**Тухайн нислэгт эзлэх%**
Хуваарьт	9093	8371	**92.1%**	**82.5%**
Хуваарьт бус	2022	1771	**87.6%**	**17.5%**
Нийт дүн	11115	10142	**91.2%**	**100.0%**

Орон нутгийн хөөрөлт, буулт

Захиалгын төрөл	Төлөвлөлт	Гүйцэтгэл	**Биелэлт%**	**Тухайн нислэгт эзлэх%**
Хуваарьт	4854	3447	**71.0%**	**43.3%**
Хуваарьт бус	4903	4520	**92.2%**	**56.7%**
Нийт дүн	9757	7967	**81.7%**	**100.0%**

Сараар

Нислэгийн төрөл

2019 оны нийт нислэгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг сараар гаргахад 07 сард төлөвлөсөн нислэгийн биелэлт хамгийн өндөр 50.8%, нийт нислэгийн тоо мөн хамгийн их буюу 14479 нислэг гүйцэтгэгдсэн байна.

Нислэгийн төрлөөр ангилан харахад өнгөрөлтийн нислэг 7 сард хамгийн их 12161 нислэг, олон улсын хөөрөлт, буултын нислэг 08 сард хамгийн их 1371 нислэг, орон нутгийн нислэгийн хувьд 07 сард хамгийн их буюу 1065 нислэг гүйцэтгэгдсэн байна.

Төлөвлөгдсөн нислэгийн биелэлтээр өнгөрөлтийн нислэг 06 сард /47.7%/, олон улсын хөөрөлт, буултын нислэг 07 сард /95.6%/, орон нутгийн нислэг 04 сард /92.4%/ тус тус өндөр гүйцэтгэлтэй байна.

Нислэгийн гүйцэтгэлийн тоогоор 07 сард хамгийн их 12161 өнгөрөлтийн нислэг, 08 сард олон улсын хөөрөлт, буултын 1371 нислэг, 07 сард 1065 орон нутгийн нислэг тус тус гүйцэтгэсэн байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 1.2 харна уу.

Нийт нислэгийн биелэлт

Сар	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Биелэлт
Jan	24481	11245	**45.9%**
Feb	21966	9810	**44.7%**
Mar	26661	12606	**47.3%**
Apr	25774	12653	**49.1%**
May	26407	12863	**48.7%**
Jun	26651	13524	**50.7%**
Jul	28483	14479	**50.8%**
Aug	28955	14352	**49.6%**
Sep	27601	13420	**48.6%**
Oct	28028	12890	**46.0%**
Nov	25816	11969	**46.4%**
Dec	26795	11961	**44.6%**

ОУ-ын өнгөрөлтийн нислэг

Сар	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Биелэлт
Jan	23028	10051	**43.6%**
Feb	20722	8848	**42.7%**
Mar	25208	11458	**45.5%**
Apr	24527	11495	**46.9%**
May	25022	11608	**46.4%**
Jun	24743	11802	**47.7%**
Jul	25961	12161	**46.8%**
Aug	26319	11990	**45.6%**
Sep	25421	11534	**45.4%**
Oct	26203	11413	**43.6%**
Nov	24322	10627	**43.7%**
Dec	25270	10676	**42.2%**

Захиалгын төрөл

2019 оны 7 сард захиалгын төрөл буюу хуваарьт, хуваарьт бус нислэг бусад саруудаас их гүйцэтгэлтэй байна.

Олон улсын өнгөрөлтийн нислэгийн 95.1% нь /11569/ хуваарьт, 4.9% нь хуваарьт бус нислэг эзэлж, олон улсын хөөрөлт, буултын нислэгийн хувьд 08 сард 75.6% нь хуваарьт, 24.4% нь хуваарьт бус нислэг тус тус эзэлж байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 1.3, график 1.1, 1.2 харна уу.

Орон нутгийн нислэгийн хувьд хуваарьт болон хуваарьт бус нислэгүүдийн нислэгт эзлэх хувь ойролцоо бөгөөд үүнээс 07 сарын нислэгийн 69.6% нь /626 нислэг/ хуваарьт бус нислэг эзэлж байсан бол 11 сарын нислэгийн 60.2% нь /365 нислэг/ хуваарьт нислэг эзэлж байсан байна.

Дэлгэрэнгүйг график 1.3 харна уу.

Утас: 71281642 И-Мэйл: fpd_office@mcaa.gov.mn
Факс:70049680 sarantogtokh.ts@mcaa.gov.mn

2018, 2019 ОНЫ НИЙТ НИСЛЭГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Нислэгийн төрлөөр

2019 онд нийт нислэг өмнөх оноос 13577 нислэг буюу 9.8%-р өссөн байна. Үүнийг нислэгийн төрлөөр задалбал:

- Өнгөрөлтийн нислэг 10367 нислэгээр буюу 8.4%-р,
- Олон улсын хөөрөлт, буулт 1637 нислэгээр буюу 19.2%-р,
- Орон нутгийн нислэг 1573 нислэгээр буюу 24.6%-р тус тус нэмэгджээ.

Орон нутгийн нислэгт дамжсан нислэгийг /Жишээ нь: УБ-УВС-ХОВД/ нэг нислэгээр бүртгэдэг байсныг 2019 онд бууж, хөөрсөн нислэг тус бүрээр задалж /УБ-УВС, УВС-ХОВД гэж 2 нислэгээр/ бүртгэж эхэлсэн тул өсөлтийн хувь өндөр гарсан байна.



Захиалгын төрлөөр

2018, 2019 оны нислэгийн өөрчлөлтийг захиалгын төрлөөр ангилан харахад олон улсын өнгөрөлтийн хуваарьт нислэг 9.0% /10355 нислэг/ нэмэгдэж, хуваарьт бус олон улсын хөөрөлт, буултын нислэг хамгийн их хувиар 46.8%, орон нутгийн хуваарьт бус нислэг 43.5%-р нэмэгдсэн байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 1.4 харна уу.

Сараар

Нислэгийн төрлөөр

2019 оны нийт нислэг өмнөх оноос 9.8%-р нэмэгдсэн ба үүнийг нислэгийн төрөл-сараар гарган харьцуулахад 04 сард хамгийн өндөр хувиар буюу 18.0% өссөн үзүүлэлттэй байна. Үүнийг нислэгийн төрлөөр харахад 04 сард өнгөрөлтийн нислэг 18.0%, 09 сард олон улсын хөөрөлт, буултын нислэг 34.2%, орон нутгийн нислэг 01 сард хамгийн их 36.2% өсжээ.

Сарын нислэгийн дундаж:

- ✈ Өнгөрөлтийн нислэг 2018 онд 10275 байсан бол 2019 онд 11139 болж 867 нислэгээр,
- ✈ Олон улсын хөөрөлт, буулт нислэг 2018 онд 709 байсан бол 845 болж 136 нислэгээр,
- ✈ Орон нутгийн нислэг өмнөх онд 533 байсан бол 664 болж 131 нислэгээр тус тус нэмэгдсэн байна.

2019 онд хоногийн нислэгийн дундаж: өнгөрөлтийн нислэг 366 болж 28 нислэгээр, олон улсын хөөрөлт, буултын нислэг 28 болж 4 нислэгээр, орон нутгийн нислэг 18 байсан бол 22 болж 4 нислэгээр нэмэгдсэн.

Дэлгэрэнгүйг хүснэгт 1.5, график 1.4 харна уу..

Нийт нислэгийн харьцуулалт



Өнгөрөлтийн нислэгийн харьцуулалт



Утас: 71281642
Факс:70049680
И-Мэйл: fpd_office@mcaa.gov.mn
sarantogtokh.ts@mcaa.gov.mn

НИСЛЭГИЙН ЗОРИЛГО

2019 оны нийт нислэгийн 90.2% нь хуваарьт, 9.8% нь хуваарьт бус нислэг эзэлж байна.

Захиалагч буюу агаарын тээвэрлэгчийн хүсэлтээр тодорхой зорилгоор гүйцэтгэсэн нислэгүүдийг түүвэрлэхэд нийт нислэгийн 1.5%, хуваарьт бус нислэгийн 15.1% буюу 2242 нислэг тодорхой зорилготой нислэг үйлдсэн байна.

Эдгээр нислэгийг зорилгоор нь ангилан үзэхэд:

- Хувийн нислэг 4.0%,
- Хөөлтийн нислэг 2.5%,
- Албан захиалгат нислэг 2.3% ,
- Тусгай үүргийн нислэг 1.6%,
- Түргэний нислэг 1.5%,
- Онцгой үүргийн нислэг 0.9%,
- Сургалт, дадлагын нислэг 0.6% гүйцэтгэл хийгдсэн байна.

Нислэгийн төрлийн хувьд авиахимийн, шүхрийн, геологийн, шалгалтын нислэг, сургалт дадлагын зорилгоор гүйцэтгэгдсэн нислэгүүд орон нутгийн нислэг байсан бол, техникийн болон түргэний техникийн нислэг өнгөрөлтийн нислэг байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 1.6 харна уу.

Харьцуулалт

2019 онд тодорхой зорилгоор гүйцэтгэсэн нислэгүүдийг 2018 онтой харьцуулахад 49.6% /743 нислэг/-р нэмэгдсэн байна. Тухайлбал орон нутгийн нислэг 69.9% /425нислэг/-р нэмэгдсэний 324 нислэг нь хувийн нислэг, 115 нислэг нь тусгай үүргийн нислэг эзэлж байна. Хамгийн их нэмэгдсэн нь хувийн нислэг 596 нислэгээр, тусгай үүргийн нислэг 118 буюу 94.4%-иар, онцгой үүргийн нислэг 81.9% нэмэгдэж, хөөлтийн нислэг нь 117 нислэг /23.7%/-р багассан байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 1.7 харна уу.

АГААРЫН ХААЛГА

Харьцуулалт

Монгол улсын 15 агаарын хаалгатай ба 2019 онд 14 агаарын хаалгаар нислэг гүйцэтгэгдсэн байна. Үүнээс 35.5% нь POLHO агаарын хаалга, 34.1% нь DARNO агаарын хаалга, 26.2% нь NIXAL агаарын хаалгаар дамжин өнгөрсөн байна. SULOK агаарын хаалгаар гүйцэтгэгдсэн нислэгийн 80.7% орж ирсэн нислэг байсан бол 19.3% нь энэ агаарын хаалгаар гарсан, DARNO агаарын хаалгаар гүйцэтгэгдсэн нислэгийн 57.5% нь хилээр гарсан, 42.5% нь орж ирсэн нислэг байна.



2018 оны дамжин өнгөрөлтийн нислэгтэй харьцуулан хамгийн их нислэг нэмэгдсэн агаарын хаалгаар эрэмбэлэн үзэхэд MORIT агаарын хаалгаар гүйцэтгэгдсэн нислэг хамгийн их буюу 5417 нислэг /32.8%/-р, NOPUS агаарын хаалгаар нислэг хамгийн өндөр хувь буюу 139.6%-р /2.4 дахин/ нэмэгдсэн бол GINOM агаарын хаалгаар гүйцэтгэгдсэн нислэг 5.3% буюу 1061 нислэгээр буурсан байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 1.8 харна уу.



ЧИГЛЭЛ

Өнгөрөлтийн нислэгийн харьцуулалт

2019 оны өнгөрөлтийн нислэгийн 51.9% нь урдаас хойшоо, 48.1% нь хойноос урагшаа чиглэлд нисэн өнгөрсөн байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад хойноос-урагшаа чиглэлийн нислэг 10.2% буюу 6418 нислэгээр, урдаас-хойшоо чиглэлийн нислэг 6.5% буюу 3949 нислэгээр нэмэгдсэн байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 1.9 харна уу.

Тухайн жилийн өнгөрөлтийн нислэгт эзлэх хувь хойноос орж ирсэн нислэгийн хувьд 0.8% нэмэгдсэн бол урдаас орж ирсэн нислэгийн эзлэх хувь 0.8% буурсан байна. Үүнийг маршрутаар дэлгэрэнгүй гаргасан.

Дэлгэрэнгүйг хүснэгт 1.10 харна уу.

Утас: 71281642 И-Мэйл: fpd_office@mcaa.gov.mn
Факс:70049680 sarantogtokh.ts@mcaa.gov.mn

ХОЁР. АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧ

АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИД

Монгол улсын агаарын зайд олон улсын 193, дотоодын 17 агаарын тээвэрлэгчдийн нислэгт зөвшөөрөл олгон ажиллажээ. Эдгээр агаарын тээвэрлэгчдийг улс, тивээр нэгтгэн гаргахад:

Тив

2019 онд нийт нислэгийн 54.7% нь Ази тивийн 15 улс, орны агаарын тээвэрлэгчид, 42.0% нь Европ тивийн 30 улс, 3.2% нь Америк тивийн 4 улс, 0.1% нь Африк тивийн 4 улсын агаарын тээвэрлэгчдийн нислэг гүйцэтгэсэн байна.



Улс

2019 онд Монгол улсын агаарын зайд 53 улсын 224 агаар тээвэрлэгч байгууллагын нийт 151772 өнгөрөлтийн болон олон улс, орон нутгийн хөөрөлт, буултын нислэг үйлдсэн байна. Үүнийг нислэгийн төрлөөр ангилбал:

- 50 улсын 193 агаарын тээвэрлэгчийн 296746 олон улсын өнгөрөлтийн нислэгт зөвшөөрөл олгон төлөвлөж 48 орны 179 агаарын тээвэрлэгчийн 133663 нислэг 140 /уламжлалт, PBN, холимог/ маршрутаар, 87 агаарын хөлгийн маягаар гүйцэтгэгдсэн бөгөөд төлөвлөгөөний биелэлт 45.0% байна.
- 28 улсын 81 агаарын тээвэрлэгчид олон улсын хөөрөлт, буултын 11115 нислэг төлөвлөж, 27 улсын 79 агаарын тээвэрлэгчийн 10142 нислэгийг 56 маршрутаар, 79 агаарын хөлгийн маягаар гүйцэтгэж, төлөвлөгөөний биелэлт 91.2% байна.
- 8 улсын 26 агаар тээвэрлэгчийн орон нутгийн хөөрөлт, буултын 9757 нислэг төлөвлөж 8 улсын 26 агаарын тээвэрлэгчийн 7967 нислэг 637 маршрутаар, 30 агаарын хөлгөөр маягаар гүйцэтгэж 81,7% биелэлттэй байлаа.

2019 оны нийт нислэгийг гүйцэтгэсэн агаарын тээвэрлэгчийн тоо, харьяалах улсаар нэгтгэн нислэгийн тоогоор эрэмбэлж хүснэгтээр харуулж байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2.1 харна уу.

Нийт нислэгт агаарын тээвэрлэгчийг нэгтгэгдэн орсон бөгөөд тухайлбал AIR CHINA, AEROFLOT агаарын тээвэрлэгчид нь өнгөрөлтийн болон хөөрөлт, буултын нислэг үйлддэг тул тус тусдаа нислэгийн төрөлдөө орж, нэгтгэлд 1 агаарын тээвэрлэгчээр орсон.

Нийт нислэгийн 34.9% нь урд хөрш БНХАУ-н агаарын тээвэрлэгчийн нислэг эзэлж байгаа бөгөөд үүнээс 29 агаарын тээвэрлэгчийн гүйцэтгэсэн өнгөрөлтийн нислэг 98.1%, олон улсын хөөрөлт, буултын 1.9%-н нислэг эзэлж байна.

ОХУ-н агаарын тээвэрлэгчдийн нислэг нийт нислэгээс 18.3%-г эзэлж, үүнээс 34 агаарын тээвэрлэгчийн өнгөрөлтийн нислэг 97.0%, 18 агаарын тээвэрлэгчийн хөөрөлт, буултын 3.0% нислэг гүйцэтгэсэн байна.

Өмнөд Солонгосын агаарын тээвэрлэгчдийн нислэг нийт нислэгийн 7.8% эзэлж, үүнээс 3 агаарын тээвэрлэгчийн өнгөрөлтийн нислэг 89.0%, 6 агаарын тээвэрлэгчийн хөөрөлт, буултын 11.%-н нислэг гүйцэтгэсэн байна. Энэ 3 улсын нислэг нийт нислэгээс 60.7%-г эзэлж байна.

БНХАУ-н агаарын тээвэрлэгчийн өнгөрөлтийн нислэгийн гүйцэтгэлийн 98.3% нь, хөөрөлт, буултын нислэгийн 95.3% нь, ОХУ-ын агаарын тээвэрлэгчийн өнгөрөлтийн нислэгийн 80.1% нь, хөөрөлт, буултын нислэгийн 86.2% нь хуваарьт нислэг байсан байна.

БНСУ-н агаарын тээвэрлэгчдийн хувьд өнгөрөлтийн нислэгийн 98.9% нь, хөөрөлт, буултын нислэгийн 93.6% нь, ХБНГУ-ын агаарын тээвэрлэгчийн өнгөрөлтийн нислэгийн 99.2% нь хуваарьт нислэг байна.

Хятад улс
Нийт нислэг- 52970
34.9%

	Авиа компани	Нислэгийн тоо
ОУӨ	29	51960
ОУХБ	5	1009
ОНХБ	1	1

Орос улс
Нийт нислэг- **27804**
18.3%

	Авиа компани	Нислэгийн тоо
ОУӨ	34	26967
ОУХБ	18	799
ОНХБ	3	38

Монгол улс
Нийт нислэг- 14386
9.5%

	Авиа компани	Нислэгийн тоо
ОУӨ	-	-
ОУХБ	9	6468
ОНХБ	17	7918

Герман улс
Нийт нислэг- 8840
5.8%

	Авиа компани	Нислэгийн тоо
ОУӨ	9	8818
ОУХБ	3	22
ОНХБ	-	-

Өмнөд солонгос улс
Нийт нислэг- 11364
7.5%

	Авиа компани	Нислэгийн тоо
ОУӨ	3	10116
ОУХБ	6	1247
ОНХБ	1	1

Утас: 71281642 И-Мэйл: fpd_office@mcaa.gov.mn
Факс:70049680 sarantogtokh.ts@mcaa.gov.mn

НИСЛЭГИЙН ТӨРӨЛ

Олон улсын өнгөрөлтийн нислэг

Төлөвлөлт, гүйцэтгэл

Олон улсын өнгөрөлтийн нислэгт 179 агаарын тээвэрлэгч 133663 нислэг гүйцэтгэж төлөвлөгөөний биелэлт 45.0% байна.

2019 онд БНХАУ-ын AIR CHINA агаарын тээвэрлэгчийн нислэг олон улсын өнгөрөлтийн нислэгт 13.0% эзэлж, үүнээс хуваарьт өнгөрөлтийн нислэг 13.9% гүйцэтгэсэн бөгөөд төлөвлөсөн нислэгээс 64.9% гүйцэтгэлтэй. Тус агаарын тээвэрлэгчийн нислэгүүд 22 чиглэлийн агаарын замаар, 9 төрлийн агаарын хөлгөөр маягаар гүйцэтгэсэн байна.

AIR CHINA агаарын тээвэрлэгчийн 17409 өнгөрөлтийн нислэгээс 99.9% буюу 17384 нислэг хуваарьт нислэг байна.

Хонконгийн CATHAY PACIFIC агаарын тээвэрлэгчийн нислэгүүд өнгөрөлтийн нийт нислэгээс 6.7% буюу 8985 нислэгийг эзэлж, төлөвлөсөн нислэгээс 37.9%-г эзэлж байна. Эдгээр нислэгүүд 12 чиглэлийн агаарын замаар, 7 төрлийн агаарын хөлгийн маягаар гүйцэтгэсэн байна. Үүнээс 8984 нислэг буюу 99.99% нь хуваарьт байсан байна.

Төлөвлөсөн нислэгийнхээ гүйцэтгэлийн биелэлтийн хувиар AIR ASTANA агаарын тээвэрлэгч 98.1%, AEROFLOT RUSSIAN AIRLINES агаарын тээвэрлэгчийн нислэг 91.2%, SIBERIA AIRLINES-ийн нислэг 84.2%, KOREAN AIR-ийн нислэг 80.1%-ийн биелэлттэй байгаа нь хамгийн өндөр биелэлтэйд тооцогдож байна.

Олон улсын өнгөрөлтийн нислэгийн 78.8%, хуваарьт нислэгийн 81.4%-н гүйцэтгэлтэй 21 агаарын тээвэрлэгчийн нислэгийг графикт харна уу.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2.2, график 2.1 харна уу.

Хосолсон үзүүлэлтүүд

2019 оны Олон улсын өнгөрөлтийн нислэгийн 78.8%-ийг гүйцэтгэсэн 21 агаарын тээвэрлэгчдийн нислэг-агаарын замаар

AIR CHINA агаарын тээвэрлэгчийн өнгөрөлтийн 17409 нислэгийн 33.0% нь GINOM-INTIK замаар, 18.1% нь INTIK-DARNO замаар, 15.1% нь INTIK- AMUTA замаар дамжин өнгөрсөн бөгөөд тус агаарын тээвэрлэгчийн нийт нислэгийн 67.0%-г эзэлж байна. Мөн AIR CHINA агаарын тээвэрлэгч нь GINOM-INTIK замын нийт өнгөрөлтийн нислэгийн 46.0%, INTIK DARNO замын нислэгийн 52.6% гүйцэтгэсэн байна. 2019 онд хамгийн их өнгөрөлтийн нислэг гүйцэтгэсэн 21 агаарын тээвэрлэгчийн нислэгийн дамжин өнгөрсөн агаарын замыг хүснэгтээс дэлгэрэнгүй харж болно.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2.3 харна уу.

2019 оны Олон улсын өнгөрөлтийн нислэгийн 78.8%-ийг гүйцэтгэсэн 21 агаарын тээвэрлэгчдийн нислэг-агаарын хөлгийн маягаар

Өнгөрөлтийн нислэгийн тоогоор тэргүүлэгч AIR CHINA агаарын тээвэрлэгчийн нислэгийн 32.0% нь A332 агаарын хөлгөөр, 22.5% нь B77W хөлгөөр, 17.1% нь A359 хөргөөр гүйцэтгэж 71.6%-г эзэлж байна. B77W агаарын хөлгөөр гүйцэтгэсэн өнгөрөлтийн нислэгийн 24.9%-г CATHAY PACIFIC, 18.6%-г AEROFLOT RUSSIAN AIRLINES, 12.0%-г CHINA EASTERN AIRLINES агаарын тээвэрлэгч гүйцэтгэсэн байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2.4 харна уу.



Харьцуулалт

2019 онд олон улсын өнгөрөлтийн нислэг 2018 оны нислэгээс 8.4% өсж, үүнээс хуваарьт өнгөрөлтийн нислэг 9.0% нэмэгдсэн байна.

Шинээр LUCKY AIR /290 нислэг/, SHANGHAI AIRLINES /178 нислэг/, ROSSIYA AIRLINES /25 нислэг/ агаарын тээвэрлэгч нар нислэг гүйцэтгэж эхэлсэн байна.

Нэмэгдсэн нислэгийн тоогоор VIETNAM AIRLINES агаарын тээвэрлэгч тэргүүлж өмнөх оноос 1600 нислэгээр буюу 70 дахин, AEROFLOT RUSSIAN AIRLINES-ийн нислэг 1296 нислэг буюу 23.7%, SIBERIA AIRLINES 1145 нислэгээр /33.7%/, SINGAPORE AIRLINES-ийн нислэг 67 дахин нэмэгдсэн байлаа.

Харин AIR FRANCE агаарын тээвэрлэгчийн өнгөрөлтийн нислэг 392 /8.9%/, HONG KONG AIRLINES-ийн нислэг 86.4%, TIANJIN AIRLINES-ийн нислэг 85.0%, AURORA AVIATION-ийн нислэг 63.4% тус тус буурсан байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2.5 харна уу.

	Нислэгийн тоо	Нийт өнгөрөлтөд эзлэх хувь	Хуваарьт нислэгийн тоо	Хуваарьт бус нислэгийн тоо
Air china	17409	13%	17384	25
	5.0% Өмнөх оноос өссөн хувь		13.9% Хуваарьт нислэгт эзлэх хувь	
Cathay pacific	8985	6.7%	8984	1
	7.7%		7.2%	
China eastern	7451	5.6%	7435	16
	14.6%		5.9%	
Korean air	7035	5.3%	6945	90
	7.2%		5.6%	
Aeroflot	6764	5.1%	6658	106
	23.7%		5.3%	

Утас: 71281642 И-Мэйл: fpd_office@mcaa.gov.mn
Факс:70049680 sarantogtokh.ts@mcaa.gov.mn

Олон улсын хөөрөлт, буулт

Төлөвлөлт, гүйцэтгэл

2019 оны олон улсын хөөрөлт, буултын нислэгийн 39.4%-г үндэсний агаарын тээвэрлэгч MIAT MONGOLIAN AIRLINES-ийн нислэг, 14.9%-г HUNNU AIR агаарын тээвэрлэгч, 9.5%-г БНХАУ-н AIR CHINA, 7.3%-г AERO MONGOLIA, 7.1%-г KOREAN AIR, 5.1%-г ОХУ-н AEROFLOT RUSSIAN AIRLINES агаарын тээвэрлэгч гүйцэтгэсэн ба нийт нислэгийн 83.2% эзэлж байна.

Төлөвлөсөн олон улсын хөөрөлт, буултын нислэгээс KOREAN AIR, TURKISH AIRLINES, ASIANA AIRLINES, JEJU AIR зэрэг агаарын тээвэрлэгчид 100% гүйцэтгэсэн бол AEROFLOT RUSSIAN AIRLINES 99.8%, AIR CHINA компани 97.9%, MIAT MONGOLIAN AIRLINES 96.4%, AIR BUSAN агаарын тээвэрлэгч 97.8%-ийн тус тус биелэлттэй байна.

Хуваарьт олон улсын хөөрөлт, буултын нислэгийн 46.4%-г үндэсний агаарын тээвэрлэгч MIAT MONGOLIAN AIRLINES, 11.5%-г AIR CHINA, 8.7%-г AERO MONGOLIA, 8.5%-г KOREAN AIR, 5.9%-г AEROFLOT RUSSIAN AIRLINES агаарын тээвэрлэгч тус тус гүйцэтгэж 86.8% эзэлж байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2.6 харна уу.

2019 оны олон улсын хөөрөлт, буултын нислэгийг гүйцэтгэсэн 16 агаарын тээвэрлэгчийн нислэг-захиалгын төрлөөр



Хосолсон үзүүлэлт

2019 оны Олон улсын хөөрөлт, буултын нислэгийн 98.2%-ийг гүйцэтгэсэн 25 агаарын тээвэрлэгч - агаарын хөлгийн маягаар

2019 оны олон улсын хөөрөлт, буултын нислэгийн 39.4% эзэлж буй MIAT MONGOLIAN AIRLINES агаарын тээвэрлэгчийн нислэгийн 62.1% нь B738 агаарын хөлгөөр, 33.7% нь B763ER хөлгөөр, HUNNU AIR компанийн нислэгийн 59.2% нь ATR72, 40.6% нь E190 агаарын хөлгөөр тус тус гүйцэтгэжээ. Олон улсын хөөрөлт, буултын нислэгийн 65.6%-г MIAT MONGOLIAN AIRLINES агаарын тээвэрлэгч, 25.5%-г AIR CHINA, 6.7%-г AEROFLOT агаарын тээвэрлэгч нар B738 агаарын хөлгөөр гүйцэтгэсэн байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2.7 харна уу.

2019 оны Олон улсын хөөрөлт, буултын нислэгийн 98.2% /хуваарьт нислэг 100%/ гүйцэтгэсэн 25 агаарын тээвэрлэгч - нэгтгэсэн агаарын замаар

MIAT MONGOLIAN AIRLINES агаарын тээвэрлэгчийн нислэгийн 59.1% - POLHO-UDA-POLHO агаарын замаар, 23.3% NIXAL-UDA-NIXAL, 21.9% INTIK-UDA-INTIK агаарын замаар нислэг үйлдсэн байна. Харин INTIK-UDA-INTIK замын нислэгийн 30.7%-г HUNNU AIR, 29.6% AIR CHINA, 26.9% MIAT MONGOLIAN AIRLINES агаарын тээвэрлэгч гүйцэтгэжээ.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2.8 харна уу.

2019 оны олон улсын хөөрөлт, буултын хуваарьт нислэг-чиглэлээр

Олон улсын хөөрөлт, буултын хуваарьт 8371 нислэгийн 46.4%-г /3885 нислэг/ гүйцэтгэсэн MIAT MONGOLIAN AIRLINES агаарын тээвэрлэгч нь үндсэн 12 чиглэлээр нислэг үйлдсэн. Нийт нислэгийн 12.0% нь Сөүлийн Инчеонд, 11.2% Бээжинд, 8.6% Хонконг, 7.8% Нарита нисэх буудалд буусан байлаа.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2.9-2.16 харна уу.

Харьцуулалт

2018, 2019 оны олон улсын хөөрөлт, буултын нислэгийг харьцуулан гаргаж үзэхэд MIAT MONGOLIAN AIRLINES агаарын тээвэрлэгчийн нислэг хамгийн их нэмэгдсэн ба 627 нислэгээр /18.6%/ нэмэгдсэн байна. Энэ жил EZNIS AIRWAYS LLC /216 нислэг/, ASIANA AIRLINES /152 нислэг/, SCAT AIRLINES /122 нислэг/ агаарын тээвэрлэгчид шинээр хуваарьт болон хуваарьт бус нислэг үйлдэж эхэлсэн. HUNNU AIR агаарын тээвэрлэгчийн нислэг өмнөх оноос 27.1% буюу 322 нислэгээр, AIR CHINA агаарын тээвэрлэгчийн нислэг 11.0% буюу 96 нислэгээр нэмэгджээ.

2019 онд KOREAN AIR-н нислэг 7.0%-р, TURKISH AIRLINES-н нислэг 0.9%-р багассан бөгөөд бусад хуваарьт нислэг үйлддэг агаарын тээвэрлэгчдийн нислэгүүд нэмэгдсэн байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2.17 харна уу.



Утас: 71281642 И-Мэйл: fpd_office@mcaa.gov.mn
Факс:70049680 sarantogtokh.ts@mcaa.gov.mn

Орон нутгийн нислэг

Төлөвлөлт, гүйцэтгэл

2019 оны Орон нутгийн нислэгийн 44.3%-г HUNNU AIR, 21.7%-г AERO MONGOLIA, 15.3%-г MIAT MONGOLIAN AIRLINES агаарын тээвэрлэгч гүйцэтгэж, орон нутгийн нислэгийн 81.2% болж байна.

Төлөвлөсөн нислэгийн гүйцэтгэлийн биелэлтээр MIAT MONGOLIAN AIRLINES агаарын тээвэрлэгчийн нислэг 98.3%, БЛУ СКАЙ АВИЭЙШН агаарын тээвэрлэгчийн нислэг 94.8%, СКАЙ ЖЕТ ХХК агаарын тээвэрлэгчийн нислэг 88.8% байв.

2019 оны орон нутгийн нислэгийн 43.3% нь хуваарьт нислэг байсан бөгөөд үүний 67.2%-г HUNNU AIR агаарын тээвэрлэгч, 32.8%-г AERO MONGOLIA агаарын тээвэрлэгч гүйцэтгэсэн байна. HUNNU AIR агаарын тээвэрлэгчийн нислэгийн 65.7%, AERO MONGOLIA-ийн 65.5% тус тус байжээ.

Хуваарьт бус нислэгийн 67.0%-г MIAT MONGOLIAN AIRLINES /27.0%/, HUNNU AIR /26.8%/, AERO MONGOLIA /13.2%/ агаарын тээвэрлэгчдийн гүйцэтгэсэн нислэг 67.0% болж байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2.18

2019 оны орон нутгийн хуваарьт нислэг-чиглэлээр

2019 онд HUNNU AIR, AERO MONGOLIA агаарын тээвэрлэгчид орон нутгийн хуваарьт нислэгийг 29 чиглэлд гүйцэтгэсэн байна. Үүнээс: 23.8% нь УБ-Ханбумбат-УБ чиглэлд, 10.4% нь ӨМГ-Ханбумбат-ӨМГ, 10.2% нь УБ-Мөрөн-УБ, 9.0% нь УБ-Өлгий-УБ, 8.3%-ийн УБ-Ховд-УБ чиглэлд нислэг үйлджээ. Нийт орон нутгийн нислэгийн 10.3% нь УБ-Ханбумбат-УБ чиглэлийн хуваарьт нислэг, 4.4% нь Мөрөн чиглэлийн, 3.9% нь Өлгийн чиглэлийн хуваарьт нислэг байжээ.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2.20 харна уу.

2019 оны орон нутгийн нислэг- агаарын тээвэрлэгч- агаарын хөлгийн маягаар

Орон нутгийн 38.3% HUNNU AIR, агаарын тээвэрлэгчийн ATR 72 хөлгөөр, 27.7% AERO MONGOLIA агаарын тээвэрлэгчийн E145 хөлгөөр, 15.3% MIAT MONGOLIAN AIRLINES агаарын тээвэрлэгчийн B738 хөлгөөр тус тус гүйцэтгэсэн нислэг байв. Энэ нь орон нутгийн нийт нислэгийн 75.3%-г эзэлж байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2.21 харна уу.

Харьцуулалт

2019 онд орон нутгийн нислэг өмнөх оноос 24.6%-р өссөн ба хуваарьт бус нислэг 43.5%, хуваарьт нислэг 6.3% нэмэгджээ. Энэ жилийн орон нутгийн нислэгийн 44.3%-г гүйцэтгэсэн HUNNU AIR агаарын тээвэрлэгчийн нислэг өмнөх оноос 576 нислэгээр буюу 19.5%, СКАЙ ЖЕТ ХХК-н нислэг 6 дахин 4.1%, 21.7%-ийг гүйцэтгэсэн AERO MONGOLIA агаарын тээвэрлэгчийн нислэг 33.4% буюу 432 нислэгээр нэмэгдэж, ТОМАС ЭЙР-ийн нислэг 84.9%-р, БЛУ СКАЙ АВИЭЙШН-ийн нислэг 14.2%-р, MIAT MONGOLIAN AIRLINES-ийн нислэг 1.5% буурсан байлаа.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2.19

HUNNU AIR

4646 төлөвлөлт	гүйцэтгэл 3527
44.3% нийт ОНХБ-д эзлэх%	19.5% өмнөх онтой харьцуулсан

AERO MONGOLIA
The Leading National Airline

2087 төлөвлөлт	гүйцэтгэл 1726
21.7% нийт ОНХБ-д эзлэх%	33.4%

MIAT MONGOLIAN AIRLINES

1241 төлөвлөлт	гүйцэтгэл 1220
15.3% нийт ОНХБ-д эзлэх%	-1.5%

СКАЙ ЖЕТ ХХК

367 төлөвлөлт	гүйцэтгэл 326
4.1% нийт ОНХБ-д эзлэх%	⬆492.7% өмнөх онтой харьцуулсан

2019 онд уламжлалт болон бүсийн навигацийн /PBN/ 140 агаарын замаар нислэг гүйцэтгэсэн байна.

Орон нутгийн нислэгийн маршрутын хувьд өмнөх онуудад хэд хэдэн чиглэлийн нислэгийг нэг нислэгт тооцож байсныг тус тусад нь нислэг гэж бүртгэдэг болсон нь: УБ-МӨ-ХОВД-УВС чиглэлийн нислэгийг нэг нислэгт тооцон бүртгэж байсныг 2019 оноос УБ-МӨ-1, МӨ-ХОВД-1, ХОВД-УВС-1 гэж тус тусад нь бүртгэж байна.

НИСЛЭГИЙН ТӨРӨЛ

Өнгөрөлтийн нислэг

Өнгөрөлтийн нислэгийн 12.0% нь NIXAL-DARNO чиглэлийн агаарын замаар өнгөрсөн бөгөөд төлөвлөсөн /40277 нислэг/ нислэгийнхээ 39.8% /16035 нислэг/ гүйцэтгэжээ. Үүний 94.3% нь хуваарьт нислэг байлаа. Хуваарьт өнгөрөлтийн 12.1% нь энэхүү агаарын замаар нисэн өнгөрсөн байна. POLHO-SERNA агаарын замаар өнгөрөлтийн нислэгийн 10.0%, хуваарьт өнгөрөлтийн 10.5% нь нисэн өнгөрч, уг агаарын замаар нисэн өнгөрч буй нислэгийн 98.3% нь хуваарьт нислэг байжээ.

Дэлгэрэнгүйг хүснэгт 3.1, график 3.1 харна уу.

Дээрх агаарын замуудыг нэгтгэн гаргаж үзэхэд нийт өнгөрөлтийн нислэгийн 22.8%-г гүйцэтгэсэн DARNO-NIXAL-DARNO чиглэлийн агаарын замаар үйлдэгдсэн нислэгийн 94.3% нь хуваарьт, 5.6% нь хуваарьт бус нислэг тус тус эзэлж байна. POLHO-SERNA-POLHO чиглэлийн агаарын замаар өнгөрөлтийн нислэгийн 18.3%, хуваарьт нислэгийн 19.2%, MORIT-NIGOR-MORIT чиглэлийн агаарын замаар нийт өнгөрөлтийн 12.3%, хуваарьт нислэгийн 10.1% тус тус гүйцэтгэсэн байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 3.2, график 3.2 харна уу.

Харьцуулалт

Өнгөрөлтийн нислэгийн 10.8%-г эзэлж буй DARNO-NIXAL замын нислэг өмнөх оноос хамгийн их буюу 2262 нислэгээр /18.5%/, MORIT-NIGOR замын нислэг 1927 нислэгээр /26.6%/, NIGOR-MORIT замын нислэг 1708 нислэгээр /30.9%/, NIXAL-SERNA замын нислэг 6.6 дахин, NOPUS-MORIT замын нислэг 5 дахин нэмэгджээ. Харин GINOM-INTIK замаар ниссэн өнгөрөлт 562 нислэгээр / 4.3%/, MORIT-SERNA замын нислэг 79.9% буюу 155 нислэгээр буурсан байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 3.3 харна уу.



Утас: 71281642
Факс:70049680
И-Мэйл: fpd_office@mcaa.gov.mn
sarantogtokh.ts@mcaa.gov.mn

Бүсийн навигацийн агаарын зам /маршрут/-ын нислэг

2019 онд нийт өнгөрөлтийн нислэгийн 56.6% буюу 75610 нислэг бүсийн навигацийн /PBN/ 9 агаарын замаар гүйцэтгэгдэж, судалгаанаас үзэхэд PBN агаарын замын ашиглалт 69.3% байна. Бүсийн навигацийн агаарын замын ашиглалтын хувиар хамгийн их нь Y478 байсан ба энэ нь тухайн замын нислэгийн 99.5%-г эзэлж байна. Нийт өнгөрөлтийн нислэгийн 18.3% нь /24497 нислэг/ PBN болон уламжлалт SERNA-POLHO-SERNA чиглэлийн Y520, A310 агаарын замаар нисэн өнгөрсөн бөгөөд үүнээс 87.7% нь /21490 нислэг/ Y520 агаарын замаар гүйцэтгэгджээ. Өөрөөр хэлбэл Y520 замаар хамгийн олон буюу 21490 нислэг бөгөөд энэ нь нийт өнгөрөлтийн нислэгийн 16.1%-г эзэлж байна. Өнгөрөлтийн нислэгийн 22.8% дамжсан DARNO-NIXAL-DARNO агаарын замын нислэгийн 59.0% нь /17993/ Y746 агаарын замаар ниссэн байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт. 3.4 харна уу.

PBN болон уламжлалт агаарын замын харьцуулалт

Бүсийн навигацийн агаарын зам /маршрут/-н ашиглалтыг өмнөх онтой харьцуулан үзвэл 28.5% буюу 16772 нислэгээр нэмэгдсэн байна.

Үүнд, Y746 буюу DARNO-NIXAL-DARNO замын нислэг хамгийн их тоогоор буюу 5361 нислэгээр, Y962 буюу MORIT-NIGOR-MORIT замын нислэг хамгийн өндөр 53 хувь буюу бүх агаарын замын нислэг нэмэгджээ.

Дэлгэрэнгүйг хүснэгт 3.5, график 3.3 харна уу.

Олон улсын хөөрөлт, буултын нислэг

Төлөвлөлт, гүйцэтгэл

Олон улсын хөөрөлт, буултын нислэгийн 32.1% INTIK, 31.4% POLHO, 1.8% NIXAL 7.1% SERNA, 6.2% DARNO, 3.6% TEBUS, 3.3% SARUL агаарын хаалгаар орж, гарсан байна. Олон улсын хөөрөлт, буултын нислэгийн 94.5% гүйцэтгэлтэй эдгээр замуудаас POLHO-UDA-POLHO замын төлөвлөгөөний биелэлт 94.7%, SERNA-UDA-SERNA замын гүйцэтгэл 94.0%, INTIK UDA INTIK замын гүйцэтгэл 91.6% биелэлттэй байжээ. Хуваарьт нислэгийн 35.3% нь POLHO-UDA-POLHO агаарын замаар гүйцэтгэсэн байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 3.6, график 3.4 харна уу.

Харьцуулалт

2019 онд олон улсын хөөрөлт, буултын нислэг INTIK-ZMUB-INTIK агаарын замаар хамгийн олон тоогоор буюу 665 нислэгээр, SULOK HN SULOK агаарын замын нислэг 16 дахин, NOPUS-UDA-NOPUS агаарын замын нислэг 3 дахин буюу 116 нислэгээр гэх мэт нэмэгдэж, SARUL-UDA-SARUL агаарын замаар 103 нислэгээр буюу 23.5% буурсан байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 3.7 харна уу.

Орон нутгийн нислэг

Төлөвлөлт, гүйцэтгэл

2019 онд орон нутгийн 9757 нислэгийг 669 маршрутаар төлөвлөж, 7967 нислэг 637 маршрутаар нислэг үйлдсэн байсан ба үүний 43.3% нь 29 чиглэлд хуваарьт нислэг үйлдсэн байна. Хуваарьт орон нутгийн нислэгийн 23.8% нь УБ-Ханбумбат-УБ чиглэлд, 10.4% нь ӨМГ-Ханбумбат-ӨМГ, 10.2% нь УБ-МӨРӨН-УБ, 9.0% нь УБ-Өлгий-УБ, 8.3% нь УБ-Ховд-УБ чиглэлд гүйцэтгэгдсэн нь нийт орон нутгийн нислэгийн 26.7%, хуваарьт нислэгийн 61.7%-г эзэлж байлаа.

Дэлгэрэнгүйг хүснэгт 3.8, график 3.5 харна уу.

Харьцуулалт

Орон нутгийн дамжаагүй шууд нислэгүүдийг харьцуулж үзэхэд Ханбумбат чиглэлийн нислэг хамгийн олон буюу 401 нислэгээр /95.5%/, Мөрөн чиглэлд 29.9%, Увс чиглэлд 44.8%, Алтай чиглэлд 61.5%, Овоотын чиглэлд 30.7% нэмэгдэж, Донойн чиглэлд 12 нислэг буюу 72.3%, Дорнодын чиглэлд 90 нислэг буюу 46.2%, Өлгийн чиглэлд 67 нислэгээр /17.8%/, Ховд чиглэлд 38 нислэгээр /11.8%/, ӨМГ чиглэлд 13 нислэгээр /6.3%/ тус тус буурсан байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 3.9 харна уу.

НИСЛЭГИЙН ТӨРӨЛ

Өнгөрөлтийн нислэг

Төлөвлөлт, гүйцэтгэл

2019 онд өнгөрөлтийн нислэг 102 агаарын хөлгийн маягаар төлөвлөгдөж 87 төрлийн агаарын хөлгийн маягаар гүйцэтгэл хийгджээ. Гүйцэтгэсэн нислэгийн тоогоор B77W маягийн агаарын хөлгийн нислэг тэргүүлж нийт өнгөрөлтийн 16.9%, хуваарьт нислэгийн 18.0%-г гүйцэтгэсэн байна.

Өнгөрөлтийн нислэгийн 55.0% нь B77W /22537 нислэг/, A359 /13690 нислэг/, A332 /13498 нислэг/, A333 /13130/, B789 /10695/ агаарын хөлгүүдээр нислэг үйлджээ.

Дэлгэрэнгүйг хүснэгт 4.1, график 4.1 харна уу.

Харьцуулалт

Энэ жил A359 агаарын хөлгөөр үйлдсэн нислэг өмнөх оноос хамгийн их тоогоор буюу 6650 нислэгээр /94.5%/, A35K хөлгийн нислэг 9 дахин /983 нислэг/, B789 хөлгийн нислэг 52.1% буюу 3665 нислэгээр нэмэгдэж, A346 хөлгийн нислэг 774 нислэгээр /47.5%/, A333 хөлгийн нислэг 733 нислэгээр /5.3%/ буурсан байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 4.2 харна уу.

	Нислэгийн тоо	Өнгөрөлтөнд эзлэх%	Хуваарьт нислэгт эзлэх %	2018 онтой харьцуулахад
B77W	22537	16.9%	18.0%	-1.4%
A359	13690	10.2%	10.9%	94.5%
A332	13498	10.1%	10.6%	-4.2%
A333	13130	9.8%	10.4%	-5.3%
B789	10695	8.0%	8.5%	52.1%
B77L	8356	6.3%	6.7%	1.3%
B772	7614	5.7%	5.5%	-3.9%
B748	7243	5.4%	5.7%	15.6%
B744	6841	5.1%	4.4%	2.4%
A320	5188	3.9%	4.1%	17.7%

Утас: 71281642 И-Мэйл: fpd_office@mcaa.gov.mn
Факс:70049680 sarantogtokh.ts@mcaa.gov.mn

Олон улсын хөөрөлт, буултын нислэг

Төлөвлөлт, гүйцэтгэл

2019 оны олон улсын хөөрөлт, буултын нислэгийн 37.3%, хуваарьт нислэгийн 43.2% B738 маягийн агаарын хөлгөөр үйлдсэн байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 4.3, график 4.2 харна уу.

Харьцуулалт

Олон улсын хөөрөлт, буултын нислэгт B738 хөлгөөр үйлдсэн нислэг 997 нислэгээр /35.8%/, E190 хөлгийн нислэг 102 дахин, A332 хөлгийн нислэг 28 дахин нэмэгдэж, F50 агаарын хөлгийн нислэг 99.5%, B747 хөлгийн нислэг 44.2%-, CL60 хөлгийн нислэг 54.3% тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 4.4 харна уу.

2018, 2019 оны олон улсын хөөрөлт, буултын нислэгийн харьцуулалт-агаарын хөлгийн маягаар



Орон нутгийн нислэг

Төлөвлөлт, гүйцэтгэл

Орон нутгийн нислэгийн 38.3%, хуваарьт нислэгийн 61.4% HUNNU AIR агаарын тээвэрлэгчийн ATR72 агаарын хөлгөөр гүйцэтгэсэн нислэг эзэлж байна. Тус агаарын хөлгөөр төлөвлөсөн нислэгийн 72.2% гүйцэтгэл хийгджээ.

Дэлгэрэнгүйг хүснэгт 4.5, график 4.3 харна уу.

Харьцуулалт

2019 онд орон нутагт E145 агаарын хөлгөөр үйлдсэн нислэг 3.4 дахин буюу 1215 нислэгээр, ATR72 хөлгийн нислэг 57.0% буюу 1108 нислэгээр нэмэгдсэн бол F50 хөлгийн нислэг 98.6% буюу 1766 нислэгээр, AT602 хөлгийн нислэг 83.3% тус тус буурсан байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 4.6 харна уу.

2018, 2019 оны орон нутгийн буулт,хөөрөлтийн нислэгийн харьцуулалт-агаарын хөлгийн маягаар



ТАВ. ӨНГӨРӨЛТИЙН НИСЛЭГ (НИСЭХ БУУДАЛ)

ТИВ

2019 онд Монгол улсын агаарын зайгаар 4 тивийн 60 улс, орны 287 нисэх буудлуудаас олон улсын өнгөрөлтийн 133663 нислэг дамжин өнгөрсөн бөгөөд эдгээр нислэгийг хөөрсөн нисэх буудлаар нь түүвэрлэж улс, тивээр ангилан гаргаж үзэхэд нийт нислэгийн 48.6% нь Ази тивийн 19 улсын 88 нисэх буудлуудаас, 43.8% нь Европ тивийн 38 улсын 174 нисэх буудлуудаас, 7.5% нь Америк тивийн 2 улсын 24 нисэх буудлаас, 0.1% нь Африк тивийн 1 улсын 1 нисэх буудлаас тус тус хөөрсөн байна.



Тайлбар: Нислэг бүрийн гарсан улс, хотын нисэх буудлаар түүвэрлэн нэгтгэсэн болно.



Утас: 71281642 И-Мэйл: fpd_office@mcaa.gov.mn
Факс:70049680 sarantogtokh.ts@mcaa.gov.mn

УЛС

2019 оны өнгөрөлтийн нислэгийн 31.8% нь БНХАУ-н 48 нисэх буудал, 12.5% нь ОХУ-ын 41 нисэх буудал, 7.0% нь ХБНГУ-ын 17 нисэх буудал, 6.5% нь Өмнөд Солонгосын 5 нисэх буудал, 6.1% нь Хонконгийн, 5.7% нь АНУ-ын 24 нисэх буудал, 5.1% нь Английн 15 нисэх буудлаас хөөрөн гарсан нислэгүүд байжээ.

Дэлгэрэнгүйг хүснэгт 5.1, график 5.1 харна уу.

2018 онтой харьцуулахад Английн нисэх буудлаас 17.1%, ОХУ-аас 16.0%, Франц улсаас хөөрөн гарсан нислэг 12.5% өсч харин Хонконг, Нидерландаас хөөрөн гарсан нислэг буурсан байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 5.2, график 5.2 харна уу.

Доор эхний 10 улсын нисэх буудлаас гарсан нислэгийг үзүүлсэн бөгөөд энэ нь нийт нислэгийн 84.7%-г эзэлж байна.



НИСЭХ БУУДАЛ

2019 онд Монгол улсын агаарын зайгаар дамжин өнгөрсөн өнгөрөлтийн нислэгийн хөөрсөн нисэх буудлуудын судалгааг дэлгэрэнгүй гарган үзүүлсэн.

Дэлгэрэнгүйг хүснэгт 5.3 харна уу.

2018, 2019 оны өнгөрөлтийн нислэгийг хөөрсөн нисэх буудлаар нь харьцуулан өссөн нислэгийн тоогоор эрэмбэлэн гаргасан.

Дэлгэрэнгүйг хүснэгт 5.4, график 5.3 харна уу.

Үүнээс нислэгийн тоогоор тэргүүлж буй 6 нисэх буудлыг дэлгэрэнгүйгээр танилцуулахад:

- Өнгөрөлтийн нислэгийн 11.2% нь БНХАУ-ын Бээжин хотын Капитал /ZBAA/ нисэх буудлаас хөөрсөн ба 2018 оны нислэгээс 0.4% өсжээ.
- Шанхайн Пудон /ZSPD/ нисэх буудлын нислэг нийт өнгөрөлтийн 10.2% эзэлж байгаа бөгөөд 1.5% нэмэгдсэн байна.
- Өнгөрөлтийн нислэгийн 6.4% нь БНСУ-ын Сөүл хотын Инчеон /RKSI/ нисэх буудлаас гарсан ба энэ нь өмнөх оноос 0.2% өссөн байна.
- Хонконгийн нисэх буудлаас /VHHH/ хөөрсөн нислэг нь өнгөрөлтийн нислэгийн 6.1% эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 3.7% буурсан байна.
- ОХУ-ын Москва хотын Шереметьево /UUEE/ нисэх буудлаас хөөрсөн нислэг нь өнгөрөлтийн нислэгийн 5.7% эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 24.3% өссөн байна.
- Германы Франкфурт /EDDF/ нисэх буудлаас хөөрсөн нислэг нь өнгөрөлтийн нислэгийн 5.0% эзэлж байгаа ба 2018 оноос 2.0% нэмэгдсэн байна.

ZBAA
Бээжин, Капитал
Нислэг- 14969
Өнгөрөлтөд эзлэх хувь-11.2%
0.4%⬆



ZSPD
Шанхай, Пудон
Нислэг- 13647
10.2%
1.5%⬆



RKSI
Сөүл, Инчеон
Нислэг- 8569
6.4%
0.2%⬆



VHHH
Хонконг
Нислэг- 8182
6.1%
-3.7%⬇



UUEE
Москва, Шереметьево
Нислэг- 7644
5.7%
24.3%⬆



EDDF
Франкфурт
Нислэг- 6749
5.0%
2.0%⬆



Утас: 71281642
Факс:70049680
И-Мэйл: fpd_office@mcaa.gov.mn
sarantogtokh.ts@mcaa.gov.mn

Нислэг хөөрсөн топ 5 нисэх буудлын нислэг
Буусан нисэх буудлаар

Монгол улсын агаарын зайгаар дамжин өнгөрсөн нислэгийн хөөрсөн нисэх буудлуудаас хамгийн олон нислэг хөөрсөн 5 нисэх буудлын нислэгийг буусан хотоор гарган үзэхэд өнгөрөлтийн нийт нислэгийн 11.2% нь БНХАУ-ын Бээжин хотын Капитал /ZBAA/ нисэх буудлаас хөөрч Орос, Европ, Америк, Африкийн 112 нисэх буудалд буусан байлаа. Үүнээс ОХУ-ын Москва хотын Шеремьетево /UUEE/ нисэх буудалд 10.5% нь /1565/, Германы Франкфурт /EDDF/ нисэх буудалд 8.7% нь /1303/, Францын Парис хотын Шарль де Голль /LFPG/ нисэх буудалд 8.6% нь /1289/ нислэг үйлдэгдсэн байна.



Мөн БНХАУ-н Шанхайн Пудон нисэх буудлаас /ZSPD/ өнгөрөлтийн нислэгийн 10.2% нь хөөрч Европ, Америк тивийн улсуудын 61 нисэх буудалд буусан байна. Шанхайн Пудон нисэх буудлаас хөөрсөн нислэгийн 18.5% нь Германы Франкфурт-/EDDF/ нисэх буудалд, 12.5% Нидерландын Амстердам-д /EHAM/, 12.3% Францын Парис хотын Шарль де Голль /LFPG/ нисэх буудалд, 11% Москва хотын Шеремьетево /UUEE/ нисэх буудалд буусан нь 54.3% болж байна.

БНСУ-н Сөүл хотын Инчеон /RKSI/ нисэх буудлаас хөөрсөн нислэгийн 14.6% нь Германы Франкфурт-/EDDF/ нисэх буудалд, 14.2% нь ОХУ-ын Москва хотын Шереметьево /UUEE/ нисэх буудалд, 9.6% нь Италийн Ром хотын Фьюмичино /LIRF/, 7.8% нь Английн Лондон хотын Хитроу /EGLL/ нисэх буудалд, 6.8% нь Австрийн Вена хотын /LOWW/ нисэх буудалд буусан нь нислэгийнхээ 52.9%-г эзэлж байна.

Хонконгийн нисэх буудлаас /VHHH/ хөөрсөн нислэгүүд Европ, Америкийн 76 нисэх буудалд бууснаас 27.6% нь Английн Лондон хотын Хитроу /EGLL/ нисэх буудалд, 10.5% нь Москвагийн Шереметьево /UUEE/-д, 8.8% нь Финландын Хельсинк /EFHK/-д, 6.6% нь Францын Парис хотын Шарль де Голль /LFPG/ нисэх буудалд буусан нь 53.5%-г эзэлж байна.

ОХУ-ын Москва хотын Шереметьево /UUEE/ нисэх буудлаас хөөрсөн 7644 нислэг Хятад, Солонгос, Гонконг, Япон, Вьетнам, Сингапур улсын 40 нисэх буудалд буусан ба үүний 24.0% нь Хятадын Шанхайн Пудон /ZSPD/-д, 22.5% нь Бээжин Капитал /ZBAA/-д, 11.9% нь Солонгосын Инчеон /RKSI/-д, 6.7% нь Гонконгийн /VHHH/ нисэх буудалд, 4.3% нь Вьетнамын Ханой- /VVNB/-д, 2.4% нь Тайландын /VTBS/ нисэх буудалд буусан байна.

Дэлгэрэнгүйг хүснэгт 5.5, график 5.4-5.8 харна уу.

Нислэг гүйцэтгэсэн агаарын тээвэрлэгчид 2019 онд хамгийн их нислэг хөөрсөн 5 нисэх буудлын нислэгийг гүйцэтгэсэн агаарын тээвэрлэгчээр гарган үзүүлж байна.

- Бээжин хотын Капитал /ZBAA/ нисэх буудлаас хөөрсөн нислэгийн 40.9% нь AIR CHINA агаарын тээвэрлэгчийн гүйцэтгэсэн нислэг /6116/, HAINAN AIRLINES HOLDING 9.1% /1369/ нислэг, AEROFLOT RUSSIAN AIRLINES 6.3% /943/, SIBERIA AIRLINES 5.9% /882/ нислэг, LUFTHANSA агаарын тээвэрлэгчийн нислэг 4.4% буюу /665/ нислэг байсан. Эдгээр агаарын тээвэрлэгчдийн нислэг Бээжин Капитал нисэх буудлаас хөөрсөн нислэгийн 66.6% эзэлж байжээ.
- Шанхайн Пудон /ZSPD/ нисэх буудлаас хөөрсөн өнгөрөлтийн нислэгийн 23.3% /3173/ нислэг, CHINA EASTERN AIRLINES компани 23.3% буюу /3173/ нислэг, AIR CHINA агаарын тээвэрлэгч 13.2% /1807/, LUFTHANSA агаарын тээвэрлэгч 6.7% /913/ нислэг эзэлж байгаа нь нийтдээ 43.2% болжээ.
- БНСУ-н Сөүл хотын Инчеон /RKSI/ нисэх буудлаас манай улсын агаарын зайгаар дамжин өнгөрсөн нислэгүүдийн 36.5% KOREAN AIR агаарын тээвэрлэгч /3128/ 36.5%, ASIANA AIRLINES агаарын тээвэрлэгч 17.0%, LUFTHANSA агаарын тээвэрлэгч 7.6% гүйцэтгэсэн нь нийтдээ 61.1% болж байна.
- 2019 оны өнгөрөлтийн нислэгийн 6.1% нь Хонконгоос /VHHH/ хөөрсөн нислэг эзэлж байгаа бөгөөд үүний 62.7%-г CATHAY PACIFIC /46.2%/, FINNAIR /8.5% /, BRITISH AIRWAYS /8.1%/ агаарын тээвэрлэгчид гүйцэтгэсэн байна.
- ОХУ-ын Москва хотын Шереметьево /UUEE/ нисэх буудлаас хөөрсөн нислэгийн 43.9% AEROFLOT AIRLINES агаарын тээвэрлэгч /3359/ нислэг, AIRBRIDGE CARGO AIRLINES агаарын тээвэрлэгч 20.3% /1551 нислэг/ , CHINA EASTERN AIRLINES агаарын тээвэрлэгч /6.5% 497/ нислэг эзэлж нийт 70.7%-г эдгээр 3 агаарын тээвэрлэгч гүйцэтгэжээ.

Дэлгэрэнгүйг хүснэгт 5.6, график 5.9-5.12 харна уу.

Бээжин хотын Капитал /ZBAA/ нисэх буудлаас хөөрсөн нислэг-гүйцэтгэсэн агаарын тээвэрлэгчээр



Утас: 71281642 И-Мэйл: fpd_office@mcaa.gov.mn
Факс:70049680 sarantogtokh.ts@mcaa.gov.mn

ӨНГӨРӨЛТИЙН НИСЛЭГИЙН АЧААЛАЛ

Агаарын навигацийн үйлчилгээний газрын Нислэгийн урсгал төлөвлөлтийн албанаас олон улсын өнгөрөлтийн нислэгийн эрчимжилтийг сар бүр өдөр, цаг, сектор, агаар зам, агаарын тээвэрлэгч, агаарын хөлгийн маягаар гарган холбогдох алба салбарууд, мэргэжилтнүүдийг нислэгийн эрчимжилтийн мэдээллээр ханган ажилладаг.

2019 оны өнгөрөлтийн нислэгээс хамгийн олон нислэгтэй сар, өдөр, цагуудын мэдээллийг түүвэрлэн авч энэхүү эмхтгэлд оруулсан.

Өнгөрөлтийн нислэг сар-өдрөөр

2019 оны өнгөрөлтийн нислэгийг сар-өдрөөр гарган хүснэгт 6.1 үзүүлсэн.

Энэ жилийн өнгөрөлтийн нислэг 07 сард 12161 нислэг гүйцэтгэсэн нь энэ жилийн хамгийн их өнгөрөлтийн нислэгтэй сар байсан бөгөөд энэ нь жилийн өнгөрөлтийн нислэгийн 9.1% эзэлж, өдрийн дундаж нислэг 393 нислэг байсан.

Харин өдрөөр гарган үзвэл 07-р сарын 05-нд хамгийн их 420 нислэг, 06-р сарын 26-нд 419 нислэг, 08-р сарын 30-нд 418 нислэг, 09-р сарын 27 нд 413, 04-р сарын 26-нд 412 өнгөрөлтийн нислэг гүйцэтгэгдсэн нь хамгийн их нислэгтэй өдрүүд байжээ.

Хилээр гарсан UTC цагаар түүвэрлэхэд хамгийн их өнгөрөлт 07-р сарын 05-ны өдрийн 20:00-20:59 цагийн хооронд 55 нислэг, 09-р сарын 07-ны 20:00-20:59 цагт 52 өнгөрөлтийн нислэгтэй байсан байна.

Хамгийн олон өнгөрөлтийн нислэгтэй 07 сарын нислэг

Төлөвлөлт, гүйцэтгэл

2019 оны 07 сард 26076 өнгөрөлтийн нислэг төлөвлөгдөж, 12161 нислэгийн гүйцэтгэл хийгдэж төлөвлөгөөний биелэлт 46.6% байна.

Нэг өдрийн нислэгийн дундаж төлөвлөлт 841 нислэг, гүйцэтгэл 392 нислэг байжээ.

07 сарын 28-ны өдөр хамгийн их өнгөрөлтийн нислэг /870 нислэг/ төлөвлөгдсөн бол төлөвлөсөн нислэгийн гүйцэтгэлээр 05-ны өдрийн биелэлт хамгийн их буюу 49.5% биелэлттэй байжээ.

Дэлгэрэнгүйг хүснэгт 6.2, график 6.1 харна уу.

07-р сарын өнгөрөлтийн нислэг-өдөр-цагаар

07-р сарын нислэгийг өдөр болон хилээр гарсан UTC -цагаар түүвэрлэн харахад 20:00-20:59 цагт энэ сарын өнгөрөлтийн нислэгийн 10.9% /1326 нислэг/ гүйцэтгэгдсэн байна. Харин 14:00-14:59 цагт хамгийн бага 124 нислэг /1.0%/ гүйцэтгэжээ.

Олон улсын өнгөрөлтийн нислэгүүд өдөр бүрийн 19:00-21:59 /UTC/ цагуудад хамгийн их ачаалалтай буюу олон нислэг манай улсын хилээр орж ирж, агаарын зайд нислэг үйлддэг, 10:00-16:59 цагийн хооронд 2-5 дахин бага нислэгтэй буюу ачаалал эрс багасдаг.

Дэлгэрэнгүйг хүснэгт 6.3 харна уу.

07-р сарын өнгөрөлтийн нислэг-хилээр гарсан UTC цагаар



2019 оны 07-р сарын өнгөрөлтийн нислэг-агаарын тээвэрлэгч-өдрөөр-давхардсан тоогоор

2019 оны 07 сарын өнгөрөлтийн нислэгийг нийт 95 агаарын тээвэрлэгч, 88 агаарын замаар 48 төрлийн агаарын хөлгөөр гүйцэтгэсэн байлаа. 07 сарын өнгөрөлтийн нислэгийн 12.9%-г /1567 нислэг/ AIR CHINA, 6.7% /819/ CATHAY PACIFIC, 6.4% буюу 775 нислэгийг CHINA EASTERN AIRLINES, 5.7% буюу 690 нислэгийг KOREAN AIR, 5.4% буюу 652 нислэгийг AEROFLOT RUSSIAN AIRLINES агаарын тээвэрлэгчид тус тус гүйцэтгэжээ.

Дэлгэрэнгүйг хүснэгт 6.4 харна уу.

07-р сарын өнгөрөлтийн нислэг – секторoор

07 сарын нислэгийн 58.3% нь Дорнод секторoор, 54.6, нь Төв, 51.9% нь Мөрөн, 43.8% нь Говь, 16.8% нь Алтай, 11.3% нь Баян секторoор тус тус дамжин өнгөрсөн байлаа.

Хамгийн их 245 нислэг 25-ны өдөр Дорнод секторoор өнгөрсөн нь тухайн өдрийн нийт өнгөрөлтийн 62.0%-г эзэлж байв.

Дэлгэрэнгүйг хүснэгт 6.5 харна уу.

07-р сарын өнгөрөлт-секторoор-давхардсан тоогоор



Хамгийн их өнгөрөлтийн нислэгтэй өдөр

Төлөвлөлт, гүйцэтгэл

2019 оны 07 сарын 05-ны өдөр 849 өнгөрөлтийн нислэг төлөвлөгдөж, 420 нислэгийн гүйцэтгэл хийгдэж төлөвлөгөөний биелэлт 49.5% байна. Үүнийг хилээр гарсан UTC цагаар гарган харахад хамгийн их нислэг 21:00-21:59 цагт 78 нислэг төлөвлөгдөж 43 нислэг гүйцэтгэж төлөвлөгөөний биелэлт 76.8% байжээ.

2019 оны 07-р сарын 05-ны өдрийн өнгөрөлтийн нислэгийн төлөвлөлт, гүйцэтгэл-хилээр гарах цагаар

Төлөв	Дүн	Хилээр гарах UTC цаг																						
		00:00	01:00	02:00	03:00	04:00	05:00	06:00	07:00	08:00	09:00	10:00	11:00	12:00	13:00	14:00	15:00	16:00	17:00	18:00	19:00	20:00	21:00	22:00	23:00
Төлөвлөлт	849	22	21	41	33	36	42	55	49	51	32	15	21	25	30	18	16	16	22	45	61	78	56	33	31
Гүйцэтгэл	420	11	14	20	18	18	22	21	22	23	15	2	12	17	6	4	7	6	13	21	26	41	43	19	19
Биелэлт /%	49.5	50.0	66.7	48.8	55	50.0	52.4	38.2	44.9	45.1	46.9	13.3	57.1	68.0	20.0	22.2	43.8	37.5	59.1	46.7	42.6	52.6	76.8	57.6	61.3

07 сарын 05-ны өдрийн өнгөрөлтийн нислэг-агаарын тээвэрлэгч

07 сарын 5-ны өдрийн өнгөрөлтийн нислэгийг 62 агаарын тээвэрлэгч, 56 маршрутаар, 31 агаарын хөлгийн маягаар гүйцэтгэсэн бөгөөд үүний 13.3% буюу 56 нислэгийг AIR CHINA агаарын тээвэрлэгч, 6.2% /26 нислэг/ CHINA EASTERN AIRLINES, 5.7% /24 нислэг/ CATHAY PACIFIC агаарын тээвэрлэгч тус тус гүйцэтгэжээ.

Дэлгэрэнгүйг хүснэгт 6.6 харна уу.

Утас: 71281642 И-Мэйл: fpd_office@mcaa.gov.mn
Факс:70049680 sarantogtokh.ts@mcaa.gov.mn

